



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 дугаар сарын 27

Дугаар 15/04

Баян-Өндөр сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.10, 20.1.11 дэх заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоолоор батлагдсан “Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 дугаар бүлгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхон аймгийн “Авто тээврийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 11 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Ээлжит XV хуралдааны 157/04 дугаар тогтоолын хавсралт



АЙМГИЙН АВТО ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР (2023-2025)

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1.Авто тээврийн салбарт тулгамдаж буй асуудал:

Авто тээврийн салбар нь орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалт, эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүчний нэг бөгөөд зонхилох үүрэг гүйцэтгэж байна. Аймгийн хэмжээнд ачаа, зорчигч тээврийн гүйцэтгэлийг статистик мэдээллээс харахад ачаа тээврийн 68 хувь, зорчигч тээврийн 92 хувийг авто замын тээврээр гүйцэтгэж байна.

Аймгийн авто тээврийн менежмент, техник, технологийн хоцрогдол, судалгаа, шинжилгээ дутмаг, түүнд шаардагдах төсөв санхүүжилт тусгагддаггүй, тээврийн хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, чадвар, туршлагатай боловсон хүчний баг, нөөц бэлтгэх бодлого алдагдсан, тээвэрлэлтийн үйл ажиллагааг саланги байдлаар зохион байгуулж ирсэн зэргээс шалтгаалан тээврийн дэд бүтэц, ажил, үйлчилгээний чанар, хүртээмж, хэрэглэгчийн эрэлт шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.

Мөн хотын доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд суудлын автомашин давамгайлснаас зорчигчид автобусаар үйлчлүүлэхээс татгалзах, улмаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний цагийн хуваарь, батлагдсан маршрут зөрчигдөж, зорчигч нь тогтоосон буудал талбайд бууж, суухгүй, дуртай газраа бууж, суух зэрэг үйлчилгээний соёл хэвшээгүй шалтгаанаас нийтийн тээврийн үйлчилгээнд хүндрэл учирч байна. Манай аймагт жилд 1500 гаруй суудлын автомашин нэмэгдэж байгаа нь гэрээгүй такси үйлчилгээ эрхлэх байдал ихсэхэд нөлөөлж, нийтийн тээврийн үйлчилгээ доголдоход хүргэж байгаа томоохон сөрөг үр дагаврыг бий болгож байна.


Хотын доторх нийтийн тээврийн үйл ажиллагаанд нөхөн олговроос гадна нийтийн тээврийн үйлчилгээнд гарах зардал, алдагдлыг тооцож, алдагдлын зөрүүг татаас хэлбэрээр орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг зарчимд шилжин нийтийн тээврийг тогтсон график цагийн хуваариар иргэдийн эрэлтэд тулгуурласан, хүлээгдэл багатай цогц үйлчилгээг бий болгох шаардлагатай байна.

Эрдэнэт хотын айл өрхийн тоо 16.5 хувь, хүн амын тоо 17.4 хувиар өсөж, гэр хорооллын 18 багийн 20 мянга гаруй өрхийн 69.1 мянга орчим иргэн, орон сууцны хорооллын 10 мянга гаруй өрхийн 38.8 мянга орчим иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэхийн тулд энэ салбарын хөгжилд тулгамдаж буй асуудлуудыг оновчтой зөв тодорхойлж, шуурхай шийдвэрлэж байх нь бидний өнөөгийн зорилт юм.

Манай орны хувьд 21 аймаг, 330 суманд ачаа, шуудан, зорчигч тээврийн үйлчилгээг хүргэх хамгийн тохиромжтой тээврийн төрөл нь авто замын тээвэр юм.

Орхон аймаг нь Баян-Өндөр, Жаргалант гэсэн 2 сумтай. Нийт 29 багтай. Нэг баг дунджаар 4.7 мянга орчим оршин суугчтай. Баян-Өндөр сум нь Монгол Улсын дундаж сумаас хүн ам хамгийн их нягтралтай.

Зураг.1 Багийн хил хязгаар ба хүн ам мянган нэгжээр



Авто тээврийн салбарын өнөөгийн байдал:


Хотын доторх нийтийн тээвэр: Өнөөдрийн байдлаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ нь аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/621 дүгээр захирамжаар (Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, зогсоолыг шинэчлэн мөрдүүлэх тухай) батлагдсан нийтийн тээврийн 6 чиглэл, такси үйлчилгээний 25 зогсоолоос зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэхээр “Автомастер төв” ХХК, “ББ-ОД” ХХК, “Тод од транс” ХХК, “Сүүтэй хадаг” ХХК-тай тээвэрлэлтийн гэрээ байгуулж, дунд оврын 23 автобус, суудлын 174 тээврийн хэрэгслээр гэрээнд тусгагдсан үнэ тарифыг мөрдөн иргэдэд үйлчилж байна. Мөн хот хооронд болон аймаг хооронд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Зураг 2. Аймгийн хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээнд байгаа тээврийн хэрэгслийн тоо



Эдгээр нийтийн тээврийн нэг чиглэл нь ойролцоогоор 20-30 мянган хүн суурьшсан багуудын нутаг дэвсгэрийг хамарсан байдлаар төлөвлөгдсөн.

Зураг 3. Нийтийн тээврийн чиглэлүүд



Зорчигч урсгалын судалгаа:

Зорчигч урсгалын судалгааг нийтийн тээврийн 6 чиглэлийн 5 буюу 83%-ийг сонгож хийсэн. Үүнд:

- 1.Их залуу- БОЭТ - Шанд – 9 Эрдэнэ зах /Ч1,Ч2 – “Тод од транс” ХХК/;
- 2.Баянтал – Дөмөг зах чиглэл /Ч3 – “ББ-ОД” ХХК/;
- 3.Сагсай – БОЭТ чиглэл /Ч4 – “ББ-ОД” ХХК/;
- 4.Говил – Город чиглэл /Ч5-“ББ-ОД” ХХК/;
- 5.Тосгон – Зээл чиглэл /Ч6 –“Сүүтэй хадаг” ХХК/;
- 5.Говил – Город /Ч5-“ББ-ОД” ХХК/;
- 6.Вокзал- Төгөл чиглэл
- 7.Жаргалант сум

Дээрх 7 чиглэлд өдөрт 18010 зорчигч тээвэрлэж байна. Өөрөөр хэлбэл такси үйлчилгээг тооцохгүйгээр хотын хүн амын 16% нийтийн тээврийн маршрутаар үйлчлүүлж, такси үйлчилгээг тооцоход өдөрт 20-25 мянган иргэн нийтийн тээврээр үйлчлүүлж байна.

График 1: Зорчигч урсгалын эзлэх хувь цагаар



График 2: Зорчигч урсгал хүнээр



Маршрутын чанарын үзүүлэлт:

Маршрутын завсрын зогсоолуудад зорчигч байхгүй тохиолдолд алгасан техникийн хурд тооцоолсон хурднаас өндөр байх тохиолдол байх боловч, эдгээр

хугацааг эцсийн буудал дээр очиж өгөгдсөн зорчигч тээвэрлэх графикийн дагуу хүлээж, тогтоосон цагийн хуваарийн дагуу хөдөлж байна.

Зураг.4 Ашиглалтын хурд ба техникийн хурд

| № | Маршрутын нэр | Ашиглалтын хурд км/цаг | Техникийн хурд км/цаг | Өдрийн зорчигч | Суудал ашиглалт |
|---|-----------------------------------|------------------------|-----------------------|----------------|-----------------|
| 1 | Их залуу- Шанд- БОЭТ- Есөн Эрдэнэ | 19.7 | 23-31 | 2000 | 63% |
| 2 | Баянтал – Дөмөг зах | 16 | 19-26.6 | 4770 | 60% |
| 3 | Сагсай - БОЭТ | 12.2 | 20-29 | 4320 | 85% |
| 4 | Говил – Город | 20 | 26-37 | 1500 | 100% |
| 5 | Тосгон –Зээл | 16.4 | 25-35 | 1700 | 100% |
| 6 | Вакзол- Төгөл чиглэл | 18 | 30-35 | 60 | 75% |
| 7 | Жаргалант – Город | - | - | 50 | - |
| | Дундаж | 16 | 21-28 | - | 78% |
| | Нийт | | | 18,010 | |

Маршрутын давхцал:


Баянтал (15.9км), Их залуу-Шанд (17.2км), Сагсай (15.9 км) маршрут орон сууцны хороолол хэсэгт 5.2 км давхацдаг өөрөөр хэлбэл эдгээр 4 маршрутын дундаж урт 17 км гэж үзвэл нийт замын уртын **31%** давхцалтай байна.¹

Баянтал (16км), Их залуу (19.7км), Шанд (17.2км) маршрут 5.7 км давхацдаг ба эдгээр 3 маршрутын дундаж замын урт 17,6 км гэж үзвэл нийт замын уртын **32%** давхцалтай байна.²

Их залуу-Шанд (17.2км) маршрут 8.1 км замын давхцалтай ба эдгээр 2 маршрутын дундаж урт 18.5 км гэж үзвэл нийт замын уртын **44%** давхцалтай байна.

Дээрхээс дүгнэж хэлбэл нийтийн тээврийн маршрутууд нь замын уртын 30-аас 45% нь давхцалтай байна. Энэ нь нийтийн тээвэрт эдийн засгийн үр ашиггүй байдлыг бий болгож байна.

Зураг 5: Нийтийн тээврийн маршрутын давхцал



Авто замын байдал:

Орхон аймаг нь авто замын сүлжээ харьцангуй өндөр хөгжсөн. Аймгийн төвийн авто замын сүлжээний дийлэнх хэсэг нь хатуу хучилттай 109,8 км авто замтай. Хотын доторх авто замуудын засвар арчлалт, тэмдэг тэмдэглэгээний ажлыг аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр “Орхон АЗЗА” ТӨХК хариуцан ажиллаж байна. 2022 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 1.4 км хатуу хучилттай авто зам, 10 байршилд авто зогсоолыг ашиглалтад оруулсан. Нийт авто замын 5089.7 м.кв талбай буюу 30 хувьд нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээний ажлыг 100 хувь хийсэн. Үүнд: Их залуу багт 3100 у/м, Дэнж, Эрдэнэ багт 940 у/м хэсэгт авто замын тэмдэглэгээ, 10 байршилд явган хүний гарцын тэмдэглэгээ, Эрх чөлөөний өргөн чөлөөний авто зам дагуу 50 ширхэг тэмдгийг суурилуулах ажил хийгдсэн. Улсын чанартай А/1001 дугаартай авто замд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2 байршилд 4 сектор гэрлэн дохиог суурилуулсан.

Замын нөхцөл байдал харьцангуй сайн, засвар, арчлалт хийдэг механизмууд нь дунджаар 8 жилийн насжилттай байна.

Тээврийн дэд бүтэц:

2022 оны байдлаар аймгийн хэмжээнд 6 чиглэлд стандартын шаардлага хангасан 99 автобусны буудал, 20 байршилд автобусны цагийн хуваарь, чиглэлийг тусгасан цахим мэдээллийн самбарыг ашиглалтад оруулсан. Цаашид стандартын шаардлага хангасан 63 автобусны буудал, сүүдрэвчийг барихаар төлөвлөж, 23 карма зогсоолыг тэмдэг, тэмдэглэгээгээр тодорхойлж, түр тоноглон ашиглаж байна.

1. 2018 онд 11 ширхэг
2. 2019 онд 9 ширхэг
3. 2020 онд 7 ширхэг
4. 2021 онд 6 ширхэг нийт 33 автобусны буудлыг шинээр ашиглалтад оруулсан.

Тус буудлууд нь шилэн сүүдрэвч бүхий сандал, хогны сав, гэрэлтүүлэг, автобусны зогсоол тэмдэг зэрэг иж бүрэн тохижилттой юм. Нийтийн тээврийн буудал зогсоолын байгууламжийг Монгол улсад мөрдөгдөж буй “Замналын зогсоол, Ангилал. Техникийн шаардлага” MNS 5879:2013 Монгол Улсын үндэсний стандарт болон Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 33 дугаар тушаалаар батлагдсан “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт” Монгол Улсын барилгын дүрмийн шаардлагад нийцүүлэн тодорхойлж, жил бүр төлөвлөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар барьж, ашиглалтад оруулж ирсэн.

Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн байдал:

Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа автобуснуудын техникийн үзүүлэлт, өнгө үзэмж муудсан, 44.4 хувь буюу 16 автобус нь 12 жилээс дээш насжилттай болж ашиглалтын хугацаа дууссан. Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12 ширхэг дунд оврын шинэ автобусыг аж ахуй нэгж байгууллагуудад дэмжлэг болгон өгсөн байна. Үүнд:

1. “Тод-од транс” ХХК-д 4 ширхэг
2. “ББ-ОД” ХХК-д 5 ширхэг
3. “Авто мастер төв” ХХК-д 1 ширхэг
4. Хот тохижуулах газарт сурагчдын автобус 1 ширхэг

5. Жаргалант суманд сурагчдын автобус 1 ширхэг

Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээг шинэ шатанд гаргах, тээврийн ажил үйлчилгээтэй холбоотой олон талт ажлыг санаачилж, оновчтой зохион байгуулж, үр дүнтэй ажиллахыг өнөөгийн нөхцөл байдал зайлшгүй шаардаж байгаа тул өсөн нэмэгдэж буй тээвэр, иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан авто тээврийг техник, технологи, цахим программ хангамжид суурилсан ухаалаг тээврийн менежменттэй болгон хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа тул “Авто тээврийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.2. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

“Автотээврийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт буюу “Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт автотээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх”

Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 5.10.1 “Ухаалаг тээврийн системд тулгуурласан хотын доторх нийтийн тээврийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлж, тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай, зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлнэ, 5.10.2 Сурагчдын автобусны буудал болон хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн авто буудал байгуулж, зорчигч тээвэрлэлтийн аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлнэ... гэж тус тус тусгаж өгсөн.

Хөтөлбөрийг боловсруулахад Монгол улсын “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэс болгов.

1.3. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Орхон аймгийн авто тээврийг хөгжүүлэх хөтөлбөр нь аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдан хөгжүүлэх, түүнд чиглэсэн орчныг бүрдүүлэх, “Эрдэнэт хотын ногоон тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025, “Цахим Эрдэнэт-1” хөтөлбөр зэрэг орон нутгийн хөгжлийн бодлоготой нягт уялдаатай хэрэгжинэ.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1.Авто тээврийн салбарын эдийн засгийн өсөлтийг хангах, эрэлтэд нийцсэн, тогтвортой, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай, байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, тээврийн үйлчилгээний тогтвортой системийг бий болгоход энэхүү бодлогын баримт бичгийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

2.2.1.Орхон аймгийн нийтийн тээвэрт дэвшилтэт техник, технологи, цахим программ хангамжид суурилсан нийтийн тээврийн үйлчилгээ, сүлжээг бий болгоно.

2.2.2.Хотын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурласан ачаа тээврийн нэгдсэн тогтолцоог бий болгон хүртээмжийг нэмэгдүүлэх замаар ачаа тээврийн логистик төв, терминалын үйлчилгээг нэвтрүүлнэ.

2.2.3.Авто тээврийн салбарын дэд бүтцийн асуудлыг төлөвлөх, зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

2.2.4.Авто тээврийн салбарт баримтлах хууль, дүрэм, журам, стандарт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангана.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Орхон аймгийн нийтийн тээвэрт дэвшилтэт техник, технологи, цахим программ хангамжид суурилсан нийтийн тээврийн үйлчилгээ, сүлжээг бий болгох зорилтын хүрээнд:

3.1.1.Хотын доторх нийтийн тээвэрт цахим картын үйлчилгээг нэвтрүүлэх,

3.1.2.Нийтийн тээврийн чиглэлүүдэд дахин төлөвлөлтийг 3 жил тутамд хийж иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр зорчих нөхцөл боломжоор хангах ажлыг зохион байгуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар суудлын автомашины хэрэглээг бууруулах,

3.1.3.Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хот хооронд, орон нутаг, дамжин өнгөрөх чиглэлийн зорчигч тээврийн авто буудлыг барьж дуусгах,

3.1.4.Зорчигч тээврийн авто буудлыг түшиглэн тасалбар, борлуулалтын цахим нэгдсэн сүлжээг бий болгож, Цахим Эрдэнэт-1 хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх,

3.1.5.Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа тээврийн хэрэгслүүдэд парк шинэчлэлтийг төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийх, байгаль орчинд ээлтэй, үр ашигтай тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх чиглэлийг барьж ажиллах,

3.1.6.Нийтийн тээвэр, такси үйлчилгээний үнэ тарифыг дотоодын нөхцөл байдалтай уялдуулан шатахууны үнийн өөрчлөлт зэрэг бодит зардал дээр үндэслэн уян хатан, шударга өрсөлдөөний бодлогоор дэмжин чөлөөт үнэ тарифт шилжүүлэх,

3.1.7.Цахим системийн үйлчилгээ нэвтрүүлснээр зорчигчдын урсгал, тээврийн хэрэгслийн хүчин чадал, парк ашиглалтын үзүүлэлт зэрэг судалгааг тогтмол гаргах,

3.1.8.Судалгааг үндэслэн үнэ төлбөргүй зорчих иргэдэд зориулсан санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудад саналыг хүргүүлэх, ажлыг зохион байгуулах,

3.1.9.Ухаалаг тээврийн системд суурилсан такси үйлчилгээг хөгжүүлж, хотын доторх такси үйлчилгээнд Цахим Эрдэнэт-1 хөтөлбөртэй уялдуулан аппликейшн нэвтрүүлэх, такси үйлчилгээний стандартыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах,

3.1.10.Такс үйлчилгээний зогсоол, буудлуудыг дахин төлөвлөж иргэдэд түргэн шуурхай үйлчлэх нөхцөл бололцоогоор хангах,

3.2.Хотын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурласан ачаа тээврийн нэгдсэн тогтолцоог бий болгон хүртээмжийг нэмэгдүүлэх замаар ачаа тээврийн логистик төв, терминалын үйлчилгээг төвлөрүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1.Аймгийн хэмжээнд “Ачаа тээврийн логистик төв”-ийг барьж байгуулах газрын асуудлыг шийдвэрлэх,

3.2.2.Ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргах, бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлэх,

3.2.3.“Ачаа тээврийн логистик төв”-ийг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд барьж байгуулах ажлыг зохион байгуулах,

3.3.Авто тээврийн салбарын дэд бүтцийн асуудлыг төлөвлөх, зохион байгуулах зорилтын хүрээнд:

3.3.1.Аймгийн хэмжээнд нийтийн тээврийн зогсоол, буудлыг төлөвлөх, стандарт шаардлага хангуулах ажлыг зохион байгуулах,

3.3.2.Цахим Эрдэнэт–1 хөтөлбөртэй уялдуулан буудал, мэдээллийн самбар, цагийн хуваарь, маршрут чиглэлийг цахим хэлбэрт шилжүүлж тоноглох,

3.3.3.Алслагдсан багийн иргэдэд нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр газрын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн нэмэгдүүлэх,

3.3.4.Нийтийн тээврийн буудал, зогсоолуудыг камержуулах, “Мэдээллийн шуурхай удирдлагын төв”-тэй хамтран хяналтыг шалгалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах

3.4.Авто тээврийн салбарт баримтлах хууль, дүрэм, журам, стандарт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд:

3.4.1.Аймгийн хэмжээнд тээвэрлэлтийн гэрээгүй үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, хууль, дүрэм, журам, стандартыг сурталчлах, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах,

3.4.2.Нийтийн тээврийн автобусны буудал, буудал орчмын авто замын 1-р эгнээг чөлөөлөх, тээврийн хэрэгсэл байршуулахгүй байх, нийтийн тээврийн хэрэгслийг аюулгүй, түргэн шуурхай зорчих нөхцөлийг бүрдүүлэх ажлыг Авто тээврийн төв, Замын цагдаагийн тасаг хамтран зохион байгуулах,

3.4.3.Дайвар, ачаа тээшний тээвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах,

3.4.4.Орон нутгийн чанартай зам болон нийтийн тээврийн үйл ажиллагаанд зам тээврийн мэргэшсэн иргэдийн болон төрийн бус байгууллагуудын уялдааг хангаж хамтран ажиллах.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1.Хөтөлбөрийг 2023-2025 он хүртэл дунд хугацаанд хэрэгжүүлнэ.

4.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах байдлаар зохион байгуулна.

4.2.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, бусад хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан орон нутгийн төрийн захиргааны байгууллага нэгдсэн удирдлагаар хангаж, Авто тээврийн төв хэрэгжилтийг хангаж ажиллана.

4.2.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Авто тээврийн төв хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлж аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжүүлнэ.

4.2.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн байгууллага, иргэн, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангана.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

5.1.Аймгийн “Авто тээврийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр нийгэм эдийн засаг, орон нутгийн хөгжил болоод автотээврийн салбарт дараах үр дүн гарна:

5.1.1.Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гарах үр дүн:

5.1.1.1.Орон нутгийн хэмжээнд авто тээврийн нэгдсэн хөтөлбөртэй болж, бодлого чиглэл, удирдлага, үйл ажиллагааны менежментийг сайжруулах боломж бүрдэж, салбарын өрсөлдөх чадвар бэхжиж аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд тулгуур болно.

5.1.1.2.Хүн амд үйлчлэх нийтийн тээврийн хүртээмж нэмэгдэж, нийгмийн халамжийн чанарт өөрчлөлт гарч, аюулгүй, түргэн шуурхай үйлчлэх боломж бүрдэнэ.

5.1.1.3.Төрийн үйлчилгээний чанар, үр дүн дээшилж, бусад салбарын хөгжлийг хангахад бодит түлхэц өгнө.

5.1.2.Аймгийн автотээврийн салбарт гарах үр дүн:

5.1.2.1.Эдийн засаг, нийгмийн эрэлтэд нийцсэн, чанартай, шуурхай, аюулгүй, хүртээмжтэй тээврийн үйлчилгээ бий болно.

5.1.2.2.Хотын доторх нийтийн тээврийн маршрутын тогтолцоо нь найдвартай, хямд, үр ашигтай хотын нийтийн тээврийн сүлжээг бий болгох боломж бүрдэнэ.

5.1.2.3.Үйлчлүүлэгчийн эрэлтэд нийцсэн тээврийн нэгдсэн уялдаа бүхий зохион байгуулалт бий болно.

5.1.2.4.Тээврийн салбарт менежментийн шинэчлэл, цахим ухаалаг тээврийн системийг нэвтрүүлснээр статистик мэдээлэл бодит болж, аж ахуй нэгжүүдийн өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

5.1.2.5.Хувийн хэвшлийн оролцоог хангасан тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх таатай нөхцөл бүрдэнэ.

5.1.2.6.Салбарын хүний нөөцийн бодлогыг хөгжүүлснээр мэргэжлийн ур чадвартай ажиллах хүчнээр хангагдаж, төрийн үйлчилгээний чанар үр дүн сайжирч, салбарын хөгжилд бодит түлхэц өгнө.

5.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг шалгах үзүүлэлт:

Энэхүү хөтөлбөрт шинээр тавигдаж буй бүх зорилтууд дараах шалгуур үзүүлэлтээр хангагдах болно.

- Эрэлт хэрэгцээнд нийцсэн
- Аюулгүй байдлыг хангасан
- Нийгэм, эдийн засгийн үр ашигтай

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | 2022 оны суурь түвшин | Зорилтот түвшин (он) | | |
|--|---|------------------------|-----------------------|----------------------|------|------|
| | | | | 2023 | 2024 | 2025 |
| Нэг. Үйлчилгээний үндсэн үзүүлэлт | | | | | | |
| 1 | Мэргэжлийн хүний нөөц | хувь | 5 | 3 | 1 | 1 |
| 2 | Зорчигч эргэлтийн өсөлт (мян.хүн.км) | хувь | 32,984 | | | |
| 3 | Ачаа эргэлтийн өсөлт(мян.тн.км) | хувь | 50,263 | | | |
| 4 | Орлогын өсөлт | Зорчигчийн Ачаа эргэлт | хувь | 12,914.8 тэрбум | | |
| 5 | Цахим үйлчилгээ /онлайн/ | | | | тоо | 1 |
| Хоёр. Дэд бүтэц | | | | | | |
| 1 | Төвлөрсөн автобуудал | тоо | 0 | 1 | | |
| 2 | НЗТҮ-ний буудал, сүүдрэвч | тоо | 99 | 3 | 3 | 3 |
| 3 | Эко тээврийн хэрэгсэл | хувь | 49.3 | 10 | 2 | 2 |
| 4 | Орон нутгийн чанартай хатуу хучилттай автозам | км | 109.8 | 0.5 | 0.5 | 0.5 |

ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТ

6.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлэн хэрэгжүүлнэ.

- 6.1.1. Улсын болон орон нутгийн төсөв,
- 6.1.2. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт,
- 6.1.3. Бусад эх үүсвэр.

ДОЛОО.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

7.1.Хөтөлбөрийн хэрэгжилтэд Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс хяналт тавьж Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэсээр жил тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

7.2.Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Авто тээврийн төв хамтран хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, дараа оны эхний улиралд багтаан аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж тайлагнана.

7.3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслэн гаргасан дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

**ОРХОН АЙМГИЙН АВТО ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Зорилтот түвшин | | | Шалгуур үзүүлэлтийн тайлбар | Мэдээлэл цуглуулах давтамж | Хариуцах байгууллага | |
|--|--|--|----------------------|-------------------------------------|------------------------------------|-----------------------------|---------------------------------------|----------------------|-------------|
| | | | Суурь түвшин 2022 он | 2023 он | 2024 он | | | | 2025 он |
| Зорилго: Авто тээврийн салбарын эдийн засгийн өсөлтийг хангах, эрэлтэд нийцсэн, тогтвортой, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай, байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, тээврийн үйлчилгээний тогтвортой системийг бий болгоход энэхүү бодлогын баримт бичгийн зорилго оршино. | | | | | | | | | |
| Зорилт 1. Авто тээврийн салбарт дэвшилтэт техник, технологи, цахим программ хангамжид суурилсан нийтийн тээврийн үйлчилгээ, сүлжээг бий болгоно. | | | | | | | | | |
| 1 | Хотын доторх нийтийн тээвэрт цахим картын үйлчилгээг нэвтрүүлнэ. | Цахим картын тоо | 7652 | 15000 | 15000 | 15000 | 2022 оны суурь түвшнээс өссөн дүнгээр | хагас, бүтэн жилээр | ХБТХОХ, АТТ |
| 2 | Хотын дотор такси үйлчилгээнд цахим систем нэвтрүүлнэ. | Такси үйлчилгээнд байгаа тээврийн хэрэгслийн тоо | 0 | 174 | 250 | 300 | 2022 оны суурь түвшнээс өссөн дүнгээр | хагас, бүтэн жилээр | ХБТХОХ, АТТ |
| 3 | Нийтийн тээврийн үйлчилгээний маршрутыг нэмэгдүүлнэ. | Маршрутын тоо | 7 | 10 | 13 | 13 | 2022 оны суурь түвшнээс өссөн дүнгээр | хагас, бүтэн жилээр | ХБТХОХ, АТТ |
| Зорилт 2. Хотын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурласан ачаа тээврийн нэгдсэн тогтолцоог бий болгон хүртээмжийг нэмэгдүүлэх замаар ачаа тээврийн логистик төв, терминалын үйлчилгээг нэвтрүүлнэ. | | | | | | | | | |
| 4 | Ачаа тээврийн логистикийн төв байгуулах ажлыг эхлүүлнэ. | тоо | 0 | Газрын асуудлыг шийдвэрлэсэн байна. | Орон нутгийн болон хувийн хэвшлийн | Үйл ажиллагаа | 2022 оны суурь түвшнээс өссөн дүнгээр | хагас, бүтэн жилээр | ХБТХОХ, АТТ |

| | | | | | | хөрөнгө оруулалт аар барьж эхэлнэ. | эхэлсэн байна. | | | | | |
|---|---|---|-------|------|------|------------------------------------|---|---------------------|-------------|--|--|--|
| Зорилт 3. Авто тээврийн салбарын дэд бүтцийн асуудлыг төлөвлөх, зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 1 | Нийтийн тээврийн авто зогсоол, буудлыг стандартын дагуу байгуулна. | Тоо | 99 | 104 | 107 | 110 | 2022 оны суурь түвшнээс өссөн дүнгээр | хагас, бүтэн жилээр | ХБТХОХ, АТТ | | | |
| 2 | Гэр хорооллын хатуу замтай авто замын сүлжээг нэмэгдүүлнэ. | км | 109,6 | 0,3 | 0,3 | 0,3 | | хагас, бүтэн жилээр | ХБТХОХ, АТТ | | | |
| Зорилт 4. Авто тээврийн салбарт баримтлах хууль, дүрэм, журам, стандарт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангана. | | | | | | | | | | | | |
| 1 | Гэрээгүйгээр такси болон авто замын 1-р эгнээ, нийтийн тээврийн зогсоол, буудлыг чөлөөлөх ажлыг зохион байгуулна. | Гэрээгүйгээр такси үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгслийн тоо | 1975 | 1500 | 1300 | 1000 | 2022 оны суурь түвшнээс буурсан дүнгээр | хагас, бүтэн жилээр | АТТ, ЗЦТ | | | |